



## ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 18/03-1

Улаанбаатар хот

### Зарим арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 51 дүгээр захирамжаар батлагдсан “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2018 оны “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоол, Засгийн Газрын 2018 оны “Агаарын бохирдлыг бууруулахад авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, мөн оны “Түүхий нүүрсийг хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2018 оны “Гишүүдэд чиглэл өгөх, ажлын төлөвлөгөө батлах тухай” 18/02 дугаар тогтоолуудаар тус тус өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хариуцсан салбартаа эрчимжүүлэн хэрэгжүүлэх, явцын мэдээлэлийг сар бүрийн эхний 7 хоногийн Баасан гаригт үндэсний хорооны Ажлын албанд тогтмол ирүүлж байхыг гишүүдэд даалгасугай.

2. Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 11, 24, 25, 26, 28 нийт 8 хорооны 26,340/хорин зургаан мянга гурван зуун дөчин/ айл өрхийг багтаан “Агаарын бохирдлыг бууруулах төслийн зорилтот хэсэг” болгон зарласугай.

3. Зорилтот хэсгийн айл өрхөд сайжруулсан түлш болон орчны бохирдлыг бууруулах санал санаачилга, шинжлэх ухаан, техник технологийн дэвшилтэт олон талт арга хэмжээг хэрэгжүүлэхийг үндэсний хорооны гишүүдэд даалгасугай.

4. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албыг өргөтгөн Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Орчны бохирдлыг бууруулах газар байгуулах ажлыг эрчимжүүлэхийг Байгаль орчин аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Сангийн дэд сайд Х.Булгантуяа нарт тус тус даалгасугай.

5. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүнд Шинжлэх Ухааны Академи, олон нийтийн мэдээллийн байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллагуудын төлөөллийг оруулан шинэчлэн зохион байгуулсугай.

6. Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн айл өрхийг сайжруулсан түлшээр хангах болон бусад байгаль орчинд ээлтэй орчин үеийн дэвшилтэт техник, технологийн төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжид бодлогын болон

санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг Хөгжлийн банк болон бусад банкаар дамжуулан зохион байгуулахыг Байгаль орчин аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт тус тус даалгасугай.

7. Засгийн газрын 2018 оны 88 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын 20,602 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд баригдах “Хүчит шонхор” дэд станцын барилга угсралтын талбайн шарилыг шилжүүлэхэд шаардагдах зардлыг 2019 оны Улсын төсөвт тусган, талбай чөлөөлөх ажлыг холбогдох журмын дагуу 2018 оны 11 дүгээр сарын 15-ны дотор шуурхай зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдод даалгасугай.

8 Стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглох, нийтийн тээвэрт ашиглагдаж буй бүх автобусанд өртөг багатай, чанар сайтай шүүлтүүр суурилуулах ажлыг зохион байгуулах, цахилгаан тээврийн хэрэгсэл болон утаагүй түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмж, утааны найрлагыг хэмжих багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, сэлбэг эд ангийг Гааль, НӨАТ-ын албан татвараас чөлөөлөх зэрэг холбогдох арга хэмжээг авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд нарт тус тус даалгасугай.

9. Өвлийн саруудад/10 дугаар сарын 01-ээс дараа оны 4 дүгээр сарын 15-ны өдрийг хамрах хугацаанд/ нийслэлийн ойролцоох сувилал, амралтын газарт 0-10 настай хүүхэдтэй гэр бүлд хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх зохицуулалтыг бий болгох асуудлыг нэн яаралтай судалж, Засгийн Газрын хуралд 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор саналаа танилцуулахыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын дэд сайд С.Мөнгөнчимэг, Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Сангийн дэд сайд Х.Булгантуяа нарт тус тус даалгасугай.

10. Агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэгдсэн стандартуудыг үнэ төлбөргүй болгож, олон нийтэд хүртээмжтэй болгохыг Стандартчилал хэмжилзүйн газрын дарга Г.Гантөмөрт, “Хатуу түлшний шаталтаас ялгарах агаар бохирдуулагч бодис, түүний хэмжээг тодорхойлох аргачлал” стандартыг төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг 2018 оны 12 сарын 15-ны дотор танилцуулахыг Эрчим хүчний сайд Х.Даваасүрэн нарт тус тус даалгасугай.

11. Ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар улирлын амралтын хуваарийг 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 15-ныг хүртэл хугацаанд тогтоох саналыг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулахыг Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд Г.Ганбаярт даалгасугай.

12. Орчны бохирдлыг бууруулахад чиглэгдсэн УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, олон нийтийн мэдлэг мэдээлэл, оролцоог

12. Орчны бохирдлыг бууруулахад чиглэгдсэн УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, олон нийтийн мэдлэг мэдээлэл, оролцоог нэмэгдүүлэхэд МҮОНРТ, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудыг үнэ төлбөргүй хамтарч ажиллахыг уриалах ажлыг зохион байгуулахыг “Утааны эсрэг ээж аавууд” төрийн бус байгууллагын тэргүүн С.Пүрэвхүү, “Монголын байгаль орчны иргэний зөвлөл” төрийн бус байгууллагын тэргүүн Б.Эрдэнэ нарт тус тус даалгасугай.

13. Онцгой албан татварын хэмжээг газрын тосны бүтээгдэхүүний төрөл, чанар, стандарт, импортолж буй боомттой уялдуулан тогтоох хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг судлан, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн дэд сайд Х.Булгантуяа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав нарт тус тус даалгасугай.


14. Агаарын чанар сайжруулах бүсэд K5 /Евро-5/ болон түүнээс дээш экологийн ангиллын стандартын шаардлага хангаагүй шатахуун худалдан борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг судлан, Агаарын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав нарт тус тус даалгасугай.

15. Шатахууны хангамж, чанарын хяналтын тогтолцоо бүрдүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл, хяналтын нэгдсэн систем бий болгох асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дарга /Б.Асралт/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга /Н.Цагаанхүү/, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга /Б.Лхагва/, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Х.Хэрлэн/ нарт тус тус даалгасугай.

16. Сайжруулсан түлш төслийн хүрээнд 2018-2019 оныг дуустал 1 жилийн хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг хавсралтаар заасан чиглэлд боловсруулж, 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр багтаан ирүүлж, батлуулан хэрэгжүүлэхийг холбогдох гишүүдэд даалгасугай.

17. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргад даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА Н.ЦЭРЭНБАТ



Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны  
 2018 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн  
 18/03-1 дугаар тогтоолын 7 хавсралт

**Сайжруулсан шахмал түлш төслийн хүрээнд  
 нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах чиглэл, хуваарь**

№	Төлөвлөгөөний чиглэл	Төлөвлөгөөг хариуцах боловсруулах байгууллага	Хариуцах эзэн
1	Олборлолт, ачилтын нарийвчилсан төлөвлөгөө	Эрчим хүчний яам “Эм Си Эс” ХХК	Сайд Ц.Даваасүрэн Гүйцэтгэх захирал Г.Батцэнгэл
2	Тээвэрлэлтийн нарийвчилсан төлөвлөгөө	Зам тээврийн хөгжлийн яам “Эрдэнэс таван толгой”	Дэд сайд Л.Халтар Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг
3	Үйлдвэрлэлийн нарийвчилсан төлөвлөгөө	Эрчим хүчний яам “Таван толгойн түлш”	Сайд Ц.Даваасүрэн Гүйцэтгэх захирал М.Ганбаатар
4	Агуулах, нөөцлөлтийн нарийвчилсан төлөвлөгөө	Батлан хамгаалахын яам Эрчим хүчний яам “Таван толгойн түлш”  “Хөгжлийн банк” “Төрийн банк”	Дэд сайд Т.Дуламдорж Сайд Ц.Даваасүрэн Гүйцэтгэх захирал М.Ганбаатар
5	Борлуулалт, түгээлтийн нарийвчилсан төлөвлөгөө	Нийслэлийн засаг даргын тамгын газар “Таван толгойн түлш”	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд Гүйцэтгэх захирал М.Ганбаатар
6	Хяналт, шалгалтын нарийвчилсан төлөвлөгөө	Нийслэлийн засаг даргын тамгын газар  Цагдаагийн Ерөнхий газар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд Дарга С.Баатаржав Дарга Н.Цагаанхүү
7	Мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааны нарийвчилсан төлөвлөгөө	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар	Сайд Н.Цэрэнбат  Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан